



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар A/264

Чойбалсан

Г Орон нутгийн өмчийн газрын дүрэм,
бүтэц, орон тоог батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, Засгийн газрын 2025 оны 37 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 527 дугаар тогтоол болон Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны “Хуульд заасан төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээ”-ний 2.3.8, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 604 дүгээр тогтоолоор баталсан зөвлөмжийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дүрмийг нэгдүгээр, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны А-1/18-19 дүгээр албан бичгээр ирүүлсэн жишиг загварын дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газрын бүтцийг хоёрдугаар, орон тооны хязгаарыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны А/183 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газар (П.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ш.ЁЛ



Аймгийн Засаг даргын 2015. оны
04 дүгээр сарын 25.-ны өдрийн
1/264.дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ
АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрэм нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг аймгийн Орон нутгийн өмчийн газар /цаашид “газар” гэх-/ын үйл ажиллагааны ажлын чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалттай холбоотой харилцааг тодорхойлоход оршино.

1.2. Газар нь үйл ажиллагаандaa Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авилгын эсрэг хууль, холбогдох хуульд нийцүүлэн гаргасан Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэр, аймгийн Засаг даргын захирамж, шийдвэр болон бусад холбогдох дүрэм, журам, эрх зүйн акт, баримт бичгүүдийг мөрдөж ажиллана.

1.3. Газар нь орон нутгийн өмчийн талаарх бодлого болон өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналтын чиг үүргийг холбогдох хууль тооомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийн хүрээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг мөн.

Хоёр. Газрын бүтэц, удирдлага, зохион байгуулалт

2.1. Газрын бүтэц, орон тооны хязгаарыг мэргэжлийн байгууллагаас гаргасан шийдвэр, зөвшөөрөл, зөвлөмж чиглэлийн хүрээнд аймгийн Засаг дарга батална.

2.2. Газар нь орон нутгийн өмчийн талаарх бодлого болон өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналттай холбоотой ажлыг аймгийн Засаг даргын өмнө бүрэн хариуцах бөгөөд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн хувьд өмчлөгчийн эрхийг хуульд заасан хязгаарын хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, өмчийн удирдлагыг Засаг дарга тус тус хэрэгжүүлэхэд мэргэжлийн арга зүй, мэдээллээр хангана.

2.3. Газрын дарга нь тус газрын хэвийн үйл ажиллагааг тогтмол хангаж, энэ дурмээр тогтоосон чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд албан хаагчдыг өдөр тутмын удирдлага, нэгдсэн зохион байгуулалт, арга зүй, чиглэлээр хангаж, байгууллагыг бүрэн төлөөлнө.

2.4.Газар нь орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой асуудлаар нийт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, орон нутгийн өмчит хуулийн этгээдийг мэргэжлийн удирдлага, нэгдсэн арга зүй, зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллана.

2.5.Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаад шаардагдах төсөв, хөрөнгө оруулалтын зардлыг аймгийн орон нутгийн төсөвт тусгана.

2.6.Газрын дарга нь жил бүр аймгийн Засаг даргатай "Жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г байгуулж, хэрэгжилтийг ханган, дүгнүүлж ажиллах бөгөөд газрын ажилтан, албан хаагчидтай жил бүр "Жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө", "Хөдөлмөрийн гэрээ"-г байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг дүгнэж ажиллана.

2.7.Байгууллага нь зохих хууль, тогтоомжийн дагуу тамга, тэмдэг, албан хэвлэмэл хуудас хэрэглэж, нягтлан бодох бүртгэлийн тайлан гаргана.

2.8.Хөдөлмөрийн хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг газрын дарга баталж, мөрдүүлнэ.

Гурав. Байгууллагын үндсэн чиг үүрэг

3.1.Холбогдох хууль, тогтоомжийн дагуу байгууллагын хэмжээнд урт, дунд, богино хугацааны баримт бичгийг боловсруулан, эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан, тайлагнаж ажиллана.

3.2.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, зохицуулалтын талаарх хууль, тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, орон нутгийн өмчит хуулийн этгээдийг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалт, зөвлөгөө, мэдээллээр ханган, асуудлыг судлан санал, дүгнэлт боловсруулах, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж, тайлагнах.

3.3.Орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэл, хөрөнгийн өөрчлөлтийн бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим болон цаасан санг бүрдүүлэх, баяжуулах, үйл ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт гаргах, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалт, зөвлөгөө, мэдээллээр хангах.

3.4.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллого зохион байгуулах, орон нутгийн дүнг нэгтгэн тайлагнах, бүртгэлээр системийн хяналт тавьж, нэгдсэн дүгнэлт, зөвлөмж, чиглэл боловсруулах, хэрэгжилтийг хангуулах.

3.5.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн болон хөрөнгийн мэдээ, тайланг хүлээн авч нэгтгэх, нэгдсэн тайлан боловсруулах, танилцуулах, холбогдох байгууллагад хүргүүлэх.

3.6.Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт бүтцийн өөрчлөлт хийх, байгуулах, өөрчлөх, нэгтгэх, татан буулгах, хувьчлах, асуудлыг судлах, санал дүгнэлт боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих.

3.7.Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, орон нутгийн өмчийн төлөөлөл, компанийн засаглалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих.

3.8.Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, хөрөнгө оруулалт, зорилтот түвшний төлөвлөлт, биелэлтийг хянах, судалгаа, шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, үр ашгийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх.

3.9.Өмч, эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад мэргэжлийн хяналтын шалгалт хэрэгжүүлж, зөрчил, дутагдлыг арилгуулах, үр дүнг тайлагнах.

3.10.Байгууллагын хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлж, албан хаагчдын нийгмийн баталгаа, сургалт, хөгжлийн асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, газрын хэмжээнд төлөвлөн, хэрэгжүүлж ажиллах.

3.11.Орон нутгийн өмчийн харилцаанд болон дотоод үйл ажиллагаанд дагаж мөрдөх журам, дүрэм, заавар, аргачлалыг боловсронгуй болгох асуудлаар санал, төсөл боловсруулах, байгууллагаас гаргаж буй эрх зүйн баримт бичгүүдийн эрх зүйн үндэслэлийг хангах.

3.12.Байгууллагын дотоод хяналт, аудитын үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлж, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг зохион байгуулах.

Дөрөв. Бусад


4.1.Энэхүү дүрмийг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцно.

4.2.Энэхүү дүрэм нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

--оо--

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ
АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН БҮТЭЦ**

Нийт орон тоо – 12



Аймгийн Засаг даргын 125 оны
№7 дүгээр сарын 15.-ны өдрийн
№6 дугаар захирамжийн хөрдугаар
хавсралт



Аймгийн Засаг даргын 200.. оны
04.. дүгээр сарын 16...-ны өдрийн
1264 дугаар захирамжийн гуравдугаар
хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ
АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ОРОН ТООНЫ ХЯЗГААР

№	Албан тушаал	Орон тоо
1	Газрын дарга	1
2	Өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн	1
3	Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн	1
4	Өмчийн удирдлага, төлөөлөл хариуцсан мэргэжилтэн	1
5	Өмчийн хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн	1
6	Хууль, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн	1
7	Хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	1
8	Өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	1
9	Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	1
10	Нягтлан бодогч	1
11	Архив, бичиг хэргийн ажилтан	1
12	Жолооч, нярав	1
Нийт		12

---оо---